

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**
/2020 оны 3 дугаар улирал/

2020 оны 09 дүгээр сарын 30

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/266 дугаар захирамжаар батлагдсан “Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”-ийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn, [Smartdarkhan](https://www.facebook.com/Smartdarkhan) цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2020 оны 3 дугаар улиралд Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 11087 өргөдөл, гомдол ирүүлснээс 10389 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 698 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93.7 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 10149 хүсэлт, 216 санал, 722 гомдол тус тус эзэлж байна. Иргэд ихэвчлэн тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээ, газар хүссэн болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн тухай өргөдөл ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 554 өргөдөл, гомдол ирүүлснээс 517 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 37 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93.3 хувьтай байна. Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ч.ЭНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ